

ТУСЛАХ МЕНЕЖЕР БОЛОН МЕНЕЖЕР

Шинэчлэгдсэн Урамшууллын системийн бүх цалин урамшуулалд хамрагдах боломжтой.

АХЛАХ МЕНЕЖЕР

Ахлах Менежерийн цалин урамшуулал авахын тулд дараах нөхцөлүүдийг хангасан байх шаардлагатай:

- 2016 оны 6-р сарын 1-ээс өмнө шинээр Захирал цолын болзол хангах
- Шинээр Захирал цолд хүрснээр Ахлах Менежер (200\$) болон Захирал цолын (500\$) эхний сарын бонусууд тооцогдож олгогдоно.
- Үүнээс хойш дараалсан 5 сарын дотор Захирал цолоо бататгасан сар бүр Ахлах Менежер болон Захирал цолын бонусууд тооцогдож олгогдоно.
- Заасан 5 сарын дотор Захирал цолоо бататгаж чадаагүй сард Ахлах Менежер болон Захирал цолын бонусууд олгогдохгүй.

ЗАХИРАЛ, АХЛАХ ЗАХИРАЛ, ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

- Одоогоор Захирал цолын бонусыг авч байгаа гишүүд 12 сарын хугацаанд (2016 оны 3-р сараас 2017 оны 2-р сар хүртэл) хуучин Урамшууллын системийн дагуу бонусаа үргэлжлүүлэн авах болно.
- Хэрэв 12 сарын хугацаанд (2016 оны 3-р сараас 2017 оны 2-р сар хүртэл) шинээр Захирал цолонд хүрсэн тохиолдолд тухайн цолын бонус нь шинэ Урамшууллын системийн дагуу олгогдож эхэлнэ. 12 сарын хугацаа өнгөрснөөс хойш (2017 оны 2-р сар) эдгээр гишүүд бүгд шинэ Урамшууллын систем уруу шилжих ба тухайн цолын олгогдоогүй үлдсэн бонус нь хүчингүй болно.

Жишээ:

Ахлах Захирал цолтой гишүүн Захирал цолын 6 удаагийн (\$400), Ахлах Захирал цолын 3 удаагийн бонусаа (\$600) авсан байлаа гэж бодъё.

- Ахлах Захирал цолтой энэ гишүүнд Захирал цолын 6 бонус, Ахлах Захирал цолын 9 бонусаа авах 12 сарын хугацаа (2016 оны 3-р сараас 2017 оны 2-р сар хүртэл) олгогдож байгаа гэсэн үг юм.
- Хэрэв Ахлах Захирал цолтой гишүүн энэ 12 сарын хугацаанд Гүйцэтгэх Захирал болсон тохиолдолд Гүйцэтгэх Захирал цолын бонусыг шинэ Урамшууллын системийн дагуу авч эхэлнэ. Энэ нь 6 удаагийн \$1,500 бонусыг 6 дараалсан сарын хугацаанд авах бөгөөд энэ хугацаандаа Захирал болон Ахлах Захирал цолын бонусаа үргэлжлүүлэн авч байна гэсэн үг юм.

ЗАХИРАЛ ЕРӨНХИЙЛӨГЧ, ИНДРАНИЛ ЕРӨНХИЙЛӨГЧ, БАДМААРАГ ЕРӨНХИЙЛӨГЧИД

Эдгээр Ерөнхийлөгч цолтой гишүүд нь хуучин системийн дагуу үргэлжлүүлэх эсхүл шинэ Урамшууллын системд шилжихээ сонгох эрхтэй. Үүнд:

- Ерөнхийлөгч цолонд хүрсэн эхний сараасаа хуучин системийн дагуу үргэлжлүүлэх эсхүл шинэ системд шилжих эсэхээ сонгох эрхтэй болно.
- Ерөнхийлөгч цолонд хүрсэн эхний сардаа өөрийн хүсэлтээ бичгээр Юниситид хүргүүлэх шаардлагатай.

ХУУЧИН СИСТЕМИЙН ДАГУУ ҮРГЭЖЛҮҮЛЭХ ХҮСЭЛТЭЙ ГИШҮҮД

- 2016 оны 3-р сараас 2018 оны 2-р сар хүртэл 24 сарын хугацаанд хуучин системийн дагуу Ерөнхийлөгчийн цалин урамшууллаа авах эрхтэй.
- Хэрэв тухайн 24 сарын хугацаанд шинээр Ерөнхийлөгч цолонд хүрсэн тохиолдолд хуучин системийн дагуу цалин урамшуулал олгогдоно.
- 24 сарын хугацаа өнгөрсний дараа 2018 оны 3-р сараас эхлэн эдгээр гишүүд шинэ систем уруу автоматаар шилжих болно.

ШИНЭ СИСТЕМ УРУУ ШИЛЖИХ ХҮСЭЛТЭЙ ГИШҮҮД

- Тус гишүүд нь шинэ Урамшууллын системийн дагуу цалин урамшууллаа шууд авах болно.

ЯМАР СИСТЕМИЙГ СОНГОСНООС ҮЛ ХАМААРАН ГИШҮҮД ШИНЭ ЕРӨНХИЙЛӨГЧ ЦОЛЫГ 3 САР ДАРААЛАН ХАМГААЛЖ ТУХАЙН ЦОЛЫН БОЛЗЛЫГ БҮРЭН ХАНГАСАНД ТООЦОГДОНО.

ОЧИР-ЭРДЭНИЙН ЕРӨНХИЙЛӨГЧ – 3 сар дараалан цолоо хамгаалан 50,000 ам. долларын нэг удаагийн бонус авна.